

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цэнхэр сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/14/СТА-ТТЗ

Хаяг: Архангай аймаг,
Эрдэнэбулган сум. Аймгийн
ЗДТГ-ын байр “А” корпус, 3
давхар зүүн жигүүр.

Цахим хуудас: www.audit.mn

2021 он

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр

Утас: 70333141

Цахим хаяг: ulambayard@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860

Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитор: П.Энхжаргал

Утас: 99743112

Цахим хаяг: enkhjargal@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага.....	10
3.5.6 Бараа материал	10
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.8 Өр төлбөр.....	12
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
3.5.10 Орлогын данс.....	13
3.5.11 Зардлын данс.....	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	14
3.7 Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	17
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	17
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	18
4. Менежментийн захидал.....	18
1.1. Орлогын данстай холбоотой асуудал.....	18
2.2 Балансын данстай холбоотой асуудал.....	19
3.1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	19
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2021. 03.31 № 139
танай _____ -ны № _____ -т

ЦЭНХЭР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.ГАЛХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Цэнхэр сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнхэр сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	749,661.6	1,578,494.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	193,523.0	882,186.3
33	АВЛАГА	314,267.1	332,094.8
35	БАРАА МАТЕРИАЛ	241,871.5	354,713.7
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	9,500.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,754,354.6	5,799,341.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,754,354.6	5,799,341.9
39200	Биет хөрөнгө	4,394,656.6	5,439,643.9
39300	Биет бус хөрөнгө	359,698.0	359,698.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,504,016.3	7,377,836.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	2,761.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	2,761.8
41300	Өглөг	0.0	2,761.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,504,016.3	7,375,074.9
51	Засгийн газрын хувь оролцоо	5,504,016.3	7,375,074.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,752,336.7	1,752,336.7
51200	Хуримтлагдсан үр дүн	1,818,839.6	3,689,898.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,932,840.0	1,932,840.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,504,016.3	7,377,836.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,271,792.2	4,920,382.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	160,309.0	853,588.6
110	Орлогын албан татвар	66,525.7	90,481.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,525.7	90,481.7
113	Хөрөнгийн албан татвар	4,230.0	4,500.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	89,553.3	758,606.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	335,966.8	1,562,176.8
120	Нийтлэг татварын бус орлого	335,966.8	1,562,176.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,775,516.3	2,504,616.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,193,828.5	2,986,995.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,193,828.5	2,986,995.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,636,969.2	2,916,799.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,668,804.3	1,873,051.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,472.9	253,203.9

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,271.7	100,656.5
2104	Хангамж, бараа материалын зардал	98,447.2	115,187.6
2105	Нормативт зардал	127,110.3	130,334.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,325.8	9,618.8
2107	Томилолт, зочны зардал	5,339.1	1,756.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,549.6	21,340.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	387,648.3	411,650.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	556,859.3	70,196.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	77,963.7	1,933,386.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	123,789.1	62,328.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-45,825.5	1,871,058.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,998,505.3	3,446,570.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	160,309.0	853,588.6
110	Орлогын албан татвар	66,525.7	90,481.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,525.7	90,481.7
113	Хөрөнгийн албан татвар	4,230.0	4,500.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	89,553.3	758,606.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	18,131.8	14,342.0
1181	Газрын төлбөр	0.0	5,051.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	71,421.5	739,213.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,680.0	88,365.1
120	Нийтлэг татварын бус орлого	62,680.0	88,365.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,775,516.3	2,504,616.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,884,148.1	2,618,979.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,884,148.1	2,618,979.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,325,357.8	2,549,381.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,668,804.3	1,872,708.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,472.9	250,442.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,439.1	105,124.8
2104	Хангамж, бараа материалын зардал	84,625.4	90,541.0
2105	Нормативт зардал	149,430.6	98,631.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,780.0	9,645.7
2107	Томилолт, зочны зардал	6,743.1	1,945.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,427.4	28,438.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,635.1	91,903.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	558,790.3	69,597.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	114,357.2	827,591.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	119,878.7	64,928.0

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,878.7	64,928.0
2200	Дотоод эх үүсвэрээр	119,878.7	64,928.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-119,878.7	-64,928.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-74,000.0	-74,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	74,000.0	74,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-79,521.5	688,663.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	273,044.5	193,523.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	193,523.0	882,186.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,752,336.67	1,932,840.04	1,864,665.06	5,549,841.77
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,752,336.67	1,932,840.04	1,864,665.06	5,549,841.77
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-45,825.48	-45,825.48
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,752,336.67	1,932,840.04	1,818,839.58	5,504,016.29
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,752,336.67	1,932,840.04	1,818,839.58	5,504,016.29
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,752,336.67	1,932,840.04	1,818,839.58	5,504,016.29
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,871,058.58	1,871,058.58
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,752,336.67	1,932,840.04	3,689,898.17	7,375,074.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,782,265.7	2,712,311.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,633,256.5	2,576,533.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,569,222.0	2,523,087.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,876,153.4	1,872,708.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	256,358.7	250,442.1

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,565.8	105,124.9
2104	Хангамж, бараа материалын зардал	91,545.6	82,562.2
2105	Нормативт зардал	115,825.8	97,850.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,645.7	9,645.7
2107	Томилолт, зочны зардал	2,650.3	1,945.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,645.6	22,989.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,831.1	79,818.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,034.5	53,446.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,034.5	53,446.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,009.2	61,778.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	74,000.0	74,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,782,265.7	2,699,961.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,873,983.9	1,852,045.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	705,383.4	735,048.6
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,500.0	45,458.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	141,398.4	67,408.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	147,269.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	134,918.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	165	165

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29444.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29444.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29444.3
2104	Хангамж, бараа материалын зардал	8628.9
2105	Нормативт зардал	781.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5449.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14585.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29444.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29444.3

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Цэнхэр сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Д.Галхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидлаар хүргүүлдэг.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 14-аас 2021 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэв.

Цэнхэр сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01/149 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цэнхэр сумын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, сумын тогтвортой хөгжлийг хангахад Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, нутгийн захиргааны манлайллыг дээшлүүлэх замаар иргэдэд төрийн чанартай үйлчилгээг үзүүлэх талаар үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулдаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн, байнга суралцагч мэргэшсэн тогтвортой, санаачилгатай цомхон чадварлаг алба байхад оршино” дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цэнхэр сум нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд төсвийн 8 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж нэгтгэлийг онлайнгаар бэлтгэж байна. Цэнхэр сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байлаа.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,768,591.0 мянган төгрөгийн 1 хувь буюу 17,685.49 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 3,049,323.6 мянган төгрөгийн 1 хувь буюу 30,493.2 мянган төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 193,523.0 мянга, эцсийн үлдэгдэл 882,186.3 мянган төгрөг болж, 688,663.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	193,523.0	882,186.3	688,663.3
Дүн	193,523.0	882,186.3	688,663.3
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
Сум хөгжүүлэх сан	138,531.6	121,687.6	-16,844.0
Орон нутгийн ерөнхий орлого	46,253.8	747,267.4	701,013.6
Орон нутгийн хөгжлийн сан	8,737.5	13,231.2	4,493.7
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	193,523.0	882,186.3	688,663.3

Эх сурвалж: Хашаат сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 84.7 хувь буюу 747,267.5 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны, 1.5 хувь буюу 13,231.2 мянган төгрөг нь ОНХСангийн, 13.8 хувь буюу 121,687.6 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 314,267.1 мянга, эцсийн үлдэгдэл 332,094.8 мянган төгрөг болж, 17,827.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн авлага	314,267.1	332,094.8	17,827.7
Дүн	314,267.1	332,094.8	17,827.7

Эх сурвалж: Цэнхэр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт байгууллагууд авлагын үлдэгдэлгүй бөгөөд СХС-ийн үлдэгдэл 332,094.8 мянган төгрөг байна.

СХСангийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 142,900.0 мянган төгрөг буюу 43.0 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 39,500.0 мянган төгрөг буюу 11.9 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, мянган төгрөг буюу 45.1 хувь нь чанаргүй зээл байна.

Аудитын илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас олгосон 189,194.8 мянган төгрөгийн 81 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 241,871.5 мянга, эцсийн үлдэгдэл 354,713.7 мянган

төгрөг болж, 112,842.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	193,384.6	279,954.7	86,570.1
Эм боох материал	3,344.1	15,391.9	12,047.8
Бичиг хэргийн материал	4,076.5	6,118.6	2,042.1
Аж ахуйн материал	22,811.6	28,711.4	5,899.8
Сэлбэг хэрэгсэл	1,313.2	1,096.5	-216.7
Түлш, шатах тослох материал	4,917.6	10,590.9	5,673.3
Барилгын засварын материал	1,706.2	6,627.0	4,920.8
Хүнсний материал	7,867.7	4,322.7	-3,545.0
Бусад хангамжийн материал	2,450.0	1,900.0	-550.0
Дүн	241,871.5	354,713.7	112,842.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Ахлах сургууль	105,174.8	188,678.8	83,504.0
ЗДТГ	28,542.8	38,438.9	9,896.1
ИТХ	2,609.9	1,824.3	-785.6
Соёлын төв	26,249.6	34,592.9	8,343.3
Цэцэрлэг	45,544.3	48,956.8	3,412.5
ЭМТ	33,750.1	42,222.1	8,472.0
Дүн	241,871.5	354,713.7	112,842.2

Эх сурвалж: Цэнхэр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл нийт дүнгээр 112,842.2 мянган төгрөгөөр өссөн боловч нэр төрлөөр авч үзвэл түүхий эд материал 98,617.7 мянган төгрөгөөр, хангамжийн материал 14,224.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Түүхий эд материалын өсөлт нь ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор эм боох материалын нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна. Мөн тайлант онд 9,500.0 мянган төгрөгийн өвсний нөөц бэлтгэсэн байна.

Нийт бараа материалын 53.2 хувь буюу 188,678.8 мянган төгрөг нь Ахлах сургуулийн, 11.9 хувь буюу 42,222.1 мянган төгрөг нь ЭМТ-ийн, 10.8 хувь буюу 38,438.9 мянган төгрөг нь ЗДТГ-ын, 13.8 хувь буюу 48,956.8 мянган төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 9.8 хувь буюу 34,592.9 мянган төгрөг нь Соёлын төвийн, 0.5 хувь буюу 1,824.3 мянган төгрөг нь ИТХ-ийн бараа материал байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Аймгийн засаг даргаас ирсэн 14,500.0 мянган төгрөгийн эм, эмнэлэгийн хэрэгсэл, нөөцийн тэжээлийг бүртгэл тайланд тусгаагүй байсныг залрууллаа.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,399,302.1 мянга, эцсийн үлдэгдэл 4,848,600.2 мянган төгрөг болж, 1,449,298.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,394,656.6	5,439,643.9	1,044,987.3

Биет бус хөрөнгө	359,698.0	359,698.0	0.0
Дүн	4,754,354.6	5,799,341.9	1,044,987.3
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Ахлах сургууль	1,901,911.3	1,812,249.8	-89,661.5
ЗДТГ	1,976,357.3	1,900,127.9	-76,229.4
ИТХ	27,076.8	23,679.9	-3,396.9
Соёлын төв	93,386.7	1,328,744.3	1,235,357.6
Хүүхдийн цэцэрлэг	258,763.6	248,821.5	-9,942.1
ЭМТ	496,858.9	485,718.5	-11,140.4
Дүн	4,754,354.6	5,799,341.9	1,044,987.3

Эх сурвалж: Цэнхэр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,150.0 мянга, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,396,761.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 32,505.5 мянган төгрөгөөр хасагдсан байна. Тайлант онд нийт 354,924.4 мянган төгрөгийн элэгдэл тооцогдсноос акталсан хөрөнгийн 32,505.5 мянган төгрөгийн элэгдэл хасагдаад нийт 322,418.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсан байна.

- Цэнхэр сумын ЗДТГ-т үлдэх өртөггүй элэгдлээ 36 нэр төрлийн 25,904.4 мянган тоног төхөөрөмж, 52 нэр төрлийн 20,509.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4 нэр төрлийн 35,440.7 мянган төгрөгийн бусад хөрөнгө нийт 81,854.8 мянган төгрөгийн хөрөнгүүдэд арга хэмжээ аваагүй байна. Байгууллагын үйл ажиллагаанд ашигладаг Си Ти Эс программыг бүртгэлд тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.3, 14.2.2 дэх заалтуудтай нийцэхгүй байна.
- Хүүхдийн цэцэрлэг- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад үндсэн хөрөнгийн шинж чанаргүй элэгдлээ бүрэн нөхсөн нийт 16301.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
- Ахлах сургууль- Элэгдлээ бүрэн нөхсөн 115ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн цаашид ашиглагдах боломжит хугацаа болон холбогдох нөхцөлийг хэлэлцүүлээгүй хөрөнгө

3.5.8 Өр төлбөр

Цэнхэр сумын ЗДТГ нь тайлант онд НДШ-ийн 2,761.8 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Хүснэгт № 5 Өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Байгууллагад төлөх өглөг		2,761.8	-
Үүнээс, байгууллагын төрлөөр			
ЗДТГ		2,761.8	-
ДҮН		2,761.8	-

Эх сурвалж: Цэнхэр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд гүйлгээ хийсэн боловч төрийн сангийн програмын асуудалтай холбоотойгоор гүйлгээ хийгдээгүйгээс өглөг үүсснийг 2021 оны 1-р сард бүрэн төлж барагдуулсан байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,016,796.6 мянга, эцсийн үлдэгдэл 5,580,193.0 мянган төгрөг болж, 1,563,396.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын хувь оролцоо	1,752,336.7	1,752,336.7	0.0
Засгийн газрын оруулсан капитал	1,752,336.7	1,752,336.7	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,818,839.6	3,689,898.2	1,871,058.6
Өмнөх үеийн үр дүн	1,864,665.1	1,818,839.6	-45,825.5
Тайлант үеийн үр дүн	-45,825.5	1,871,058.6	1,916,884.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,932,840.0	1,932,840.0	0.0
Дүн	5,504,016.3	7,375,074.9	1,871,058.6
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	5,042,480.0	6,908,061.2	1,865,581.2
Төсөл, сан	461,536.3	467,013.7	5,477.4
Дүн	5,504,016.3	7,375,074.9	1,871,058.6

Эх сурвалж: Цэнхэр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,375,074.9 мянган төгрөг болж 1,871,058.6 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.10 Орлогын данс

Цэнхэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 4,920,382.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 1,648,590.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 531,733.5 мянган төгрөгийн устгах бичилт хийгдсэн байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

- Татварын орлого 853,588.6 мянган төгрөг,
- Татварын бус орлого 1,562,176.8 мянган төгрөг байна. Үүнээс: Хүү торгуулийн орлого 14,750.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 11,786.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,529,434.0 мянган төгрөг, бусад орлог 6,206.0 мянган төгрөг байна.
- Тусламж санхүүжилтийн орлого 2,504,616.8 мянган төгрөг байна. Үүнээс: улсын төсвөөс 1,867,620.8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих 45,458.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 29,444.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 562,093.4 мянган төгрөг байна.

3.5.11 Зардлын данс

Цэнхэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 2,986,995.6 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 550.0 мянган төгрөг, нийт 3,048,773.6 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос 1,871,058.6 мянган болж өссөн нь үнэ төлбөргүй хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалсан байна. Тайлант жилд 531,733.5 мянган төгрөгийн давхардсан гүйлгээг устгах бичилт хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь нийт 15,334.7 мянган төгрөгийн түлш халаалтын зардлыг зарцуулсан бөгөөд тус зардлаас 4,988.5 мянган төгрөгөөр тамгын газрын халаалтыг засварласан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна. Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 44,227.3 мянган төгрөгийг зарцуулахдаа сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, зөвлөлийн хурлаар шийдвэрлээгүй байгаа нь 2018 оны 12 сарын 31-ны өдрийн 318 тоот тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1 "Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн

- тухайн шатны засаг даргын захирамжаар зарцуулна" гэсэн заалттай нийцээгүй байна.
- ЭМТ- Бараа үйлчилгээний бусад зардалд 9412.6 мянган төгрөг зарцуулсан бөгөөд 100 хувь түүвэрлэн үзэхэд зориулалт бусаар 3549.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүний 2500.0 мянган төгрөгөөр нь хөрөнгө бэлтгэсэн, 1049.1 мянган төгрөгөөр нь шатахуун авсан байна.Цалингийн давтан тооцооллыг 4 сард Л.Гантөмөрт суутгалыг буруу тооцоолон 78.3 мянган төгрөг илүү олгосон байна.
 - Ахлах сургууль- Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй 58,228.7 мянган төгрөгийн анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Орон нутгийн төсвийн орлогыг 121,216.9 мянган төгрөгөөр анх төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг 35,658.9 мянган төгрөгөөр бууруулан 85,558.0 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Цэнхэр сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 5 дугаар тогтоолоор тухайн сум тайлант онд 144,790.1 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 876,214.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 6 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 6. Сумын орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1.НИЙТ ОРЛОГО	144,790.1	876,214.6	731,424.5	605.2
2.УРСГАЛ ОРЛОГО	144,790.1	876,214.6	731,424.5	605.2
3.ТАТВАРЫН ОРЛОГО	136,790.1	853,588.6	716,798.5	624.0
4.Орлогын албан татвар	56,150.0	90,481.7	34,331.7	161.1
Хүн амын орлогын албан татвар	56,150.0	90,481.7	34,331.7	161.1
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар			-	
Үйл ажиллагааны орлого	4,200.0	4,418.0	218.0	105.2
Хөрөнгийн орлого	35,000.0	36,836.3	1,836.3	105.2
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	250.0	2,965.0	2,715.0	1,186.0
Шууд бус орлого	16,700.0	46,262.4	29,562.4	277.0
Өмчийн татвар	4,080.0	4,500.0	420.0	110.3
Үл хөдлөх хөрөнгийн татвар			-	
Бууны албан татвар	4,080.0	4,500.0	420.0	110.3
Бусад татвар	23,243.0	19,393.3	(3,849.7)	83.4
Улсын тэмдэгтийн хураамж	3,700.0	4,016.3	316.3	108.5
Газрын төлбөр:	3,563.0	5,051.3	1,488.3	141.8
Газрын төлбөр		369.3	369.3	
Газрын дуудлага худалдааны орлого	3,563.0	4,682.0	1,119.0	131.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	390.0	390.0	-	100.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15,590.0	9,935.7	(5,654.3)	63.7
Байгалийн нөөц ашигласны төлбөр:	53,317.1	739,213.6	685,896.5	1,386.4
Байгалийн ургамал ашигласны төлбөр	186.0	683,405.0	683,219.0	367,422.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	26,380.0	22,533.2	(3,846.8)	85.4
Ойн нөөц ашигласны төлбөр	26,635.1	32,435.4	5,800.3	121.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	116.0	840.0	724.0	724.1
5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,000.0	22,626.0	14,626.0	282.8

Төсөвт газрын өөрийн орлого	1,500.0	1,669.7	169.7	111.3
Хүү, торгуулийн орлого	4,000.0	14,750.3	10,750.3	368.8
Нэр заагдаагүй бусад орлого	2,500.0	6,206.0	3,706.0	248.2

Аудитын илрүүлэлт: Орлого нийт дүнгээрээ давж биелсэн боловч 2 нэр төрлийн орлого 9,501.1 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Хог хаягдлын хураамжийн орлого 5,654.3 мянган төгрөгөөр,
2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 3,846.8 мянган төгрөгөөр,

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төсвийн төлөвлөлт

Цэнхэр сумын ИТХ-ын 2020 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 2,902,633.6 мянган төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор 2,782,265.3 мянган төгрөг болж 120,367.7 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт 7. Сумын төсвийн төлөвлөлт

/мянган төгрөг/

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн татварын орлого	137,048.0	143,290.1	6,242.1
2	ТЭЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	86,407.1	86,407.1	0.0
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	343,835.2	326,177.0	-17,658.2
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	69,115.5	66,271.7	-2,843.8
5	СӨБ-ийн үйлчилгээ	341,127.3	296,860.8	-44,266.5
6	ЕБС-ийн үйлчилгээ	1,317,176.1	1,229,310.3	-87,865.8
7	Соёлын үйлчилгээ	91,173.3	91,173.3	0.0
8	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	489,188.0	487,783.7	-1,404.3
9	2019 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	20,000.0	46,253.8	26,253.8
10	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	7,562.5	8,737.5	1,175.0
	Нийт дүн	2,902,633.0	2,782,265.3	-120,367.7
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	94,933.0	94,933.0	0.0
2	Засаг даргын тамгын газар	407,450.2	422,287.9	14,837.7
3	Орон нутгийн хөгжлийн сан	76,678.0	75,009.2	-1,668.8
4	Сум хөгжүүлэх сан	75,000.0	75,000.0	0.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	341,127.3	296,860.8	-44,266.5
6	Ерөнхий боловсролын сургууль	1,325,083.2	1,237,217.4	-87,865.8
7	Соёлын төв	93,173.3	93,173.3	0.0
8	Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ	489,188.0	487,783.7	-1,404.3
	Нийт дүн	2,902,633.0	2,782,265.3	-120,367.7

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн зарим нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн баталсан бол

1. ЭМТ-ийн тогтмол зардал 1,404.3 мянган төгрөгөөр,

2. Аймагт ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл цуцлагдаж орох орлого буурсан зэрэгтэй уялдуулан орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 1,668.8 мянган төгрөгөөр
3. Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын /сургууль, цэцэрлэг/ үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс 132,132.3 мянган төгрөгөөр тус тус хасаж тодотгол хийгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 2,782,265.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,633,256.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 75,009.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 74,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 705,383.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 61,500.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,873,983.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгээс, 141,398.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Харин төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,712,311.8 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь урсгал зардлаас 56,722.7 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 13,231.2 мянган төгрөг хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12 төсөл, арга хэмжээнд 75,009.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 13 арга хэмжээ бүрэн хэрэгжиж гүйцэтгэлээр 61,778.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 2 арга хэмжээ хэрэгжээгүйгээс 13,231.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 26,435.8 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,008.5 мянга, нийт 29,444.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 8,628.9 мянга, хоол хүнсний зардалд 781.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 5,449.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 14,585.0 мянга, нийт 29,444.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

- ТЕЗ- Шилэн дансны цахим хуудсанд 101 мэдээлэл байршуулахаас 99 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.
- ЗДТГ- Шилэн дансны цахим хуудаст нийт 107 мэдээлэл байршуулахаас 88 мэдээллийг хугацаанд нь 19 мэдээллийг хугацаа хоцроож, төсөв өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэрийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4

- дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.10 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.
- ИТХ- Шилэн дансны цахим хуудаст нийт 49 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаанд нь 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.10 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.
 - Хүүхдийн цэцэрлэг- Шилэн дансны хуулийн дагуу холбогдох 149 мэдээлэл байршуулахаас 145 мэдээлэл хугацаанд нь мэдээллэж, 21 мэдээ хугацаа хоцроож байршуулсан. 18845.2 мянган төгрөгийн 4 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.
 - ЭМТ- Шилэн дансны цахим системд 139 мэдээлэл хугацаанд нь мэдээллэж, 23 мэдээ хугацаа хоцроож байршуулсан, 10 мэдээллийн огт мэдээлээгүй, 16465,5 мянган төгрөгийн 7 тушаал шийдвэр байршуулаагүй байна.
 - Ахлах сургууль- Шилэн дансны хуулийн дагуу 124 мэдээлэл оруулахаас 39 мэдээлэл хугацаа хоцроосон

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 50,992.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	1	15,726.9	1	15,726.9			91.3%
Нийт	1	15,726.9	1	15,726.9			91.3%

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хог хаягдлын хураамжийн орлого 7,010.9 мянган төгрөгөөр тасарсан байсанд зөвлөмж хүргүүлсэн хэдий ч тайлант онд мөн 5,654.3 мянган төгрөгөөр тасарсан тул зөвлөмжийн биелэлтийг 91.3 гэж үзлээ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан ЗДТГ, ИТХ, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн байна. Хүснэгтээр харуулвал:

Хүснэгт №9.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо			Аудитын санал дүгнэлтийн төрөл
	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Үүнээс Зөрчилгүй
		Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	
Ахлах сургууль	1	1		1
Хүүхдийн цэцэрлэг	1	1		1
ЗДТГ	1	1		1
ИТХурал	1	1		1
Эрүүл мэндийн төв	1	1		1
Соёлын төв	1		1	
ОНХС	1		1	

СХС	1		1	
НИЙТ ДҮН	8	5	3	5

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 319,564.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 14,500.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 78.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 90,525.6 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 214,460.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүлээ.

Хүснэгт №10. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчил		Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
							Төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	7	148,020.5	1	14,500.0	6	133,520.5			3	51,665.8	3	81,854.7
ИТХурал	2	-			2	-			1		1	
ЭМТ	6	78,168.5			6	78,168.5	1	78.3	2	20,014.6	3	58,075.6
Хүүхдийн цэцэрлэг	4	35,146.8			4	35,146.8			1	18,845.2	3	16,301.6
Соёлын төв	1				1	-			1			
Ахлах сургууль	3	58,228.7			3	58,228.7			1		2	58,228.7
НИЙТ ДҮН	23	319,564.5	1	14,500.0	22	305,064.5	1	78.3	9	90,525.6	12	214,460.6

Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цэнхэр сумын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.1. ОРЛОГЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн 17 нэр төрлийн орлогоос 2 нэр төрлийн орлого 9,501.1 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Хог хаягдлын хураамжийн орлого 5,654.3 мянган төгрөгөөр,
2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 3,846.8 мянган төгрөгөөр,

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1.2 Эрсдэл:

- Сумын ИТХ-аар баталсан Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө орлогын нэр төрлөөр биелэгдээгүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байх
- Орон нутгийн Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэхгүй байх

1.1.3 Өгсөн зөвлөмж:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах

- Орлого тасарч байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох

1.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

2.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

2.2.1 Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангаас олгосон 189,194.8 мянган төгрөгийн 81 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.

2.2.2 Эрсдэл:

Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

2.2.3 Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй дорвитой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах

2.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1.1.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 101 мэдээлэл байршуулахаас 99 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.

3.1.2.Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль хэрэгжихгүй байх, мэдээллийн ил тод байдал хангагдахгүй байх

3.1.3.Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6.2.4.”хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт” гэсэн заалтыг хэрэгжүүлэн мэдээллийг хугацаанд нь шилэн дансанд мэдээлж ажиллах

3.1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 12 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Цэнхэр сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН

Бэлтгэсэн: Аудитор *Phal* П.Энхжаргал

Анхан шатанд хянасан: Аудитын менежер *J. Jisshe* Т.Байгалмаа

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор *Dmy* Д.Уламбаяр

Хавсралт1

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Цэнхэр сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021			APA-2021/14/СТА-ТТ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Цэнхэр сумын ТЕЗ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Орон нутгийн 14 нэр төрлийн орлогоос 2 нэр төрлийн орлого 9,501.1 мянган төгрөгөөр тасарсан байна.	9,501.1	Зөвлөмж хүргүүлэв	Засаг дарга, Санхүү дарга	Д.Галхүү, Д.Сүхбаатар
2	Сум хөгжүүлэх сангаас олгосон 241,913.2 мянган төгрөгийн 21 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна	189,194.8	Зөвлөмж хүргүүлэв	Засаг дарга, Санхүү дарга	Д.Галхүү, Д.Сүхбаатар
3	Шилэн дансны цахим хуудсанд 101 мэдээлэл байршуулахаас 99 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.		Зөвлөмж хүргүүлэв	Засаг дарга, Санхүү дарга	Д.Галхүү, Д.Сүхбаатар
	Дүн	198,695.9			

APA-2021/14/СТА-ТТ3